



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20¹⁷ он⁰⁵ дугаар
сарын¹⁸-ны өдөр

Дугаар Xэг/
845

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.БААСАНХҮҮ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн тоог бууруулах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан Таны асуулгын хариуг холбогдох байгууллагаар бэлтгүүлэн үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

001644

2017 оны 05 дугаар сарын 18 –ний
өдрийн тоот албан бичгийн хавсралт

АСУУЛГЫН ХАРИУ

2017.05.17

Улаанбаатар хот

Нэг. Монгол Улсын хэмжээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд тавих хяналт, эрх зүйн орчны талаар

Монгол Улс нь Мансууруулах бодисын тухай 1961 оны конвенцид 1990 онд, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенцид 1999 онд, Мансууруулах бодис ба сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг 1988 оны конвенцид 2001 онд, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн конвенцид 2008 онд тус тус нэгдэн орсноор олон улсын өмнө тодорхой үүрэг, хариуцлага хүлээж байна.

Монгол Улсын Засгийн газрын зүгээс мансууруулах бодисын талаарх олон улсын санаачлага зорилго, зорилтыг хангах чармайлт гаргаж 2002 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг баталж, 2002 онд баталсан Эрүүгийн хуулиар дээрх төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг тогтоож, 2000-2005 онд хар тамхи, мансууруулах бодисын эсрэг үндэсний хөтөлбөр батлуулан хэрэгжүүлсэн.

2003 онд Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн алба /UNODC/-ны хооронд Вена хотноо харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, Засгийн газар холбогдох байгууллага, агентлагийн чадавхийг бэхжүүлэх, сургалт явуулах, техник хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

Мөн 2005 онд Москва хотноо ОХУ-ын Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих Холбооны алба, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран энэ мансууруулах бодис тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлттэй тэмцэх талаар хамтран ажиллах хэлэлцээр байгуулсан бөгөөд хэлэлцээрийн хүрээнд Монгол Улс 2006 оноос эхлэн “Канал” нэгдсэн арга хэмжээнд жил бүр ажиглагчаар, 2007 онбос Хил орчмын бус нутгийн хууль хяналтын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах тухай нэмэлт протоколыг батлан, хамтран хэрэгжүүлж байна.

Сүүлийн үед лабораторийн аргаар боловсруулсан мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хэрэглэж байгаагаас үзэхэд уг бодисын нэр төрөл олширч, хурдан үйлчлэл бүхий мансуурах бодис хэрэглэгч, зуучлагч, тээвэрлэгчийн давхарга, сүлжээ бий болсон байна.

Цагдаагийн байгууллагаас 2006-2016 онд үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэрэгт дүн шинжилгээ хийхэд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг нийт

гэмт хэргийн 0,2 хувийг, үүнээс 82,1 хувь нь Улаанбаатар хотод, 17,9 хувь нь хөдөө орон нутагт, жилд дунджаар 32, сард 2,7 гэмт хэрэг үйлдэгдэж буй судалгааг гаргажээ.

Мөн дээрх төрлийн гэмт хэрэгт холбогдож буй хүмүүсийг нас, хүйсээр нь авч үзвэл 81,9 хувь нь эрэгтэй, үүнээс 18-24 насны залуучууд 65 хувийг эзэлж байгаа нь уг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хууль бус эргэлтэд хяналт тавих ажлыг чангатгах, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, алба хаагчдыг сургаж, мэргэшүүлэх ажлыг эрчимжуулэхийг шаардаж байна.

Дээрх нөхцөл байдлыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулж, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлууллаа.

Уг хөтөлбөрийн зорилго нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналтад тавих тухай хуулийн хэрэгжилтийг хангах, энэхүү бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, дээрх бодисын хууль бус эргэлтээс олсон хөрөнгөөр санхүүжүүлж болзошгүй үндэстэн дамнасан зохион байгуулалтай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх ажлыг төрийн нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалтаар хангах явдал юм.

Дээрх хөтөлбөрийн хүрээнд үндсэн 5 зорилт дэвшүүлж, түүний хүрээнд зохион байгуулах ажил, авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тусгасан.

Тухайлбал:

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох,
- Төрийн байгууллагуудыг нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлыг оновчтой болгох, чиг үүрэг бүхий байгууллагын үүргийн давхардалыг арилгаж, уялдаа холбоог сайжруулах,
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах,
- Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах, тэдгээрийг арилгах арга замыг оновчтой тодорхойлох,
- Хууль сахиулах, эрүүл мэнд, шүүх эрх мэдлийн байгууллагуудын алба хаагчдыг мэргэшүүлэх, анхан шатны илрүүлэгч болон шинжлэн судлах зориулалт бүхий орчин үеийн багаж, техник хэрэгслээр хангах чиглэлээр

зорилт дэвшиүүлж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017-2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлаад байна.


Хоёр. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдлын талаар

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны /UNODC/ 2011 оны тайланд Баруун Европ, Америкт каннабисийн, Алс болон Ойрхи дорнод, Зүүн өмнөд Азид амфетамин, синтетик төрлийн хар тамхины хэрэглээ, үйлдвэрлэгч орнууд нэмэгдэж, энэ төрлийн хар тамхины зах зээл өргөжиж байна. Хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудын эдийн засаг, хууль эрх зүйн болон бусад сул талыг ашиглан зохион байгуулалтай гэмт бүлэг, бүлэглэлүүд мансууруулах бодисын үйлдвэрлэлээ эдгээр улсууд уруу шилжүүлж байгаа тухай дурджаэ.

Цагдаа, хил, гаалийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээс үзвэл Монгол Улс уруу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус нийлүүлэлт БНХАУ, ОХУ болон зүүн өмнөд азийн орнуудаас гэсэн 3 урсалаар амфетамин, метамфетамины төрлийн болон мансууруулах ургамлын гаралтай бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан гэмт хэрэг, зөрчил ихсэж байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлээр сүүлийн арван жилд /2006-2016 он/ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 188, 192-196 дугаар зүйлд заасан /mansuuruuлах болон сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, улсын хил нэвтрүүлэх/ гэмт хэрэг 388 бүртгэгдэж, 1112 хүн холбогдон шалгагдсан байна.

2006-2016 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэл, холбогдогчийн тоог хүснэгтээр үзүүлбэл:



Өнөөдрийн байдлаар хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт ял шийтгэгдэн ял эдэлж буй 66 ялтан /эрэгтэй- 57, эмэгтэй -9/, цагдан хоригдон шалгагдаж буй 22 /эрэгтэй-13, эмэгтэй -9/ сэжигтэн байна.

2006-2010 онд энэ төрлийн гэмт хэргийн ихэнх хувийг манай оронд ургадаг мансууруулах үйлчилгээтэй зэрлэг олсны ургамал /каннабис/-ын төрлийн бодисыг олж авах, хадгалах, борлуулах, илгээх гэмт хэрэг эзэлж байсан бол 2011 оноос химиин аргаар боловсруулсан сэтгэцэд нөлөөт бодис болох амфетамин, метамфетамин агуулсан мөс /ICE/ гэх нэршилтэй бодисын хэрэглээ, гэмт хэргийн гаралт, холбогдогчдын тоо тогтмол өсч, нас залуужиж байна.

Тухайлбал сүүлийн 3 жилийн байдлаар уг гэмт хэрэгт холбогдсон холбогдогчийн насын байдалд судалгаа хийвэл, 18 насын буюу насанд хүрээгүй холбогдогчийн тоо 2 дахин, 19-25 насын холбогдогч 24.2 хувиар, 26-35 насын холбогдогч 38 хувиар, 35-аас дээш насын холбогдогч 3.6 хувиар тус тус өсчээ.

Сүүлийн жилүүдэд хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр нэвтрүүлэх арга, хэлбэр улам нарийсан олон улсын шуудан илгээмж, цахилгаан бараа, ахуйн болон хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүнд нуух, бусдад дайх хэлбэрээр хууль бусаар хил нэвтрүүлэх, борлуулахдаа товлосон газарт нууж үлдээх, төлбөр тооцоог урьдчилж бусдын данс ашиглан авах, шилжүүлэх зэргээр нарийн зохион байгуулалттай үйлдэж байна.

Өнөөдрийн байдлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас ихэвчлэн амфетамин, метамфетамины төрлийн мөс /ICE/ болон мансууруулах ургамлын гаралтай шавар /Hashish/, Оросын Холбооны Улсаас сэтгэцэд нөлөөт анданте зэрэг эм нийлүүлэгдэх болсон бөгөөд 2010-2016 оны хооронд дээрх гэмт хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос хархад амфетамин, метамфетамины төрлийн бодисоос давамгайлах хандлагатай болсон. /Хүснэгтээр харуулав./

он он	бодисын нэр Каннабис /грамм/	Мөс /грамм/	Гашш /грамм/	Эксиз /ширхэг/	Мансууруулах сэтгэцэд нөлөөт эм ширхэг/	Мими /грамм/	Кокайн /грамм/	Геройн /грамм/
2010								1,7 кг
2011	5,8 кг	30	0,4		15978			
2012	3,112 кг	124	92	22	20			5,4 кг
2013	4,979 кг	61,7	198,8		25	150		
2014	13841	140,74	15,5		137	3,940		
2015	9808,21	344,164	24,51	4	2331	800		
2016	10816	625,5	89,9	3	654	10,820	0,4	

Монгол Улсын иргэд гадаад оронд зорчихдоо хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдон 2006 оноос эхлэн шалгагдах болсон бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 117 хүн шалгагдсан байна.

Үүнээс хууль бусаар тээвэрлэсэн 13, хадгалсан 15, хилээр нэвтрүүлсэн 41, хэрэглэсэн 39, бусдад дамжуулсан гэх зүйл ангиар 1 иргэн тус тус шүүхээс ял шийтгэгдсэн бөгөөд 2016 оны эхний 10 сарын байдлаар 9 хэрэгт 9 иргэн холбогdon шалгагдаж байна. /Хүснэгтээр харуулав./

Огноо	Шалгагдсан улс, орон											НИЙТ
	БНХАУ	ОХУ	ЧЕХ	КАЗАКСТАН	ГЕРМАН	МАЛАЙЗ	УНГАР	БАНГЛАДЕШ	ГРЕК	БОЛГАР	СЛАВАК	
2006	2											2
2007	4											4
2008	2			3								5
2009	1	2				1	1	1				6
2010	11											11
2011	19						2	2				23
2012		3									1	4
2013	1		1			4						6
2014	7		1									8
2015	35				1							36
2016	12											12

Гурав. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнээс үрьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг сүүлийн жилүүдэд өсч байгаад хэд хэдэн үндсэн хүчин зүйлс нөлөөлж байна.


Тухайлбал, газар зүй, геополиткийн нөхцөл байдал, манай орны зарим нутаг дэвсгэрт мансууруулах төрлийн ургамал хяналтгүй ургадаг, түүнийг устгах ажил хангалтгүй зохион байгуулагддаг, хүүхэд, залуучууд бие биесээс сонсох, даган дуурайх, цахим сүлжээнд энэ төрлийн мэдээлэл хяналтгүй цацагдаж байгаа, уг гэмт хэрэгтэй тэмцэх, хяналт тавих чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагын уялдаа муюу, хяналт, шинжилгээ хийх зориулалт бүхий техник, технологи шаардлага хангахгүй болсон, үрьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хангалтгүй, хэрэглэгч, донточ болсон тохиолдолд үзүүлэх эмнэлгийн болон сэтгэл зүйн, нийгмийн тусламж үйлчилгээний стандарт байхгүй зэрэг нөхцөл байдал зэргээс тус тус шалтгаалж байна.

Үүнээс гадна хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгч нарын дунд хийсэн нарийвчилсан суурь судалгаа байхгүйгээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулж чадахгүй байна.

Хэдийгээр хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгч нарын суурь судалгааг Нийслэлийн эрүүл мэндийн газар, Глобал сантай хамтран 2010 онд, Хууль зүй, дотоод хэргийн яам, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран 2011 онд тус тус хийсэн боловч 74.000-90.000 орчим хэрэглэгч байна гэсэн дүн гарсан нь судалгааны зорилго, арга зүй, шалгуур үзүүлэлт өөр өөр байснаас шалтгаалж зөрүүтэй дүн гарч байжээ.

Мөн Байгаль орчин, ногоон хөгжлийн яам /хуучин нэрээр/-ны санхүүжилтээр Цагдаагийн ерөнхий газар, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар, Шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэнтэй хамтран 2014 онд улсын хэмжээнд зэрлэг байдлаар, хяналтгүй ургаж буй мансууруулах болон сэтгэцэд нөлөөт ургамлын тархацын байдалд судалгаа хийсэн.

Уг судалгаагаар мансууруулах болон донтуулах үйлчилгээтэй бодис бүхий ургамал болох намуу, зэрлэг олс, зээргэнэ, лантанз зэрэг 9 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйл ургамал нь манай улсын 14 аймгийн 49 гаруй сумын нутаг дэвсгэрт 15,000 орчим га талбайд ургаж байна гэсэн судалгааг гаргажээ. /Байршилыг зургаар харуулав/



Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны /хуучин нэрээр/ Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас 2013 онд мансууруулах, донтуулах үйлчилгээтэй бодис бүхий ургамлыг 1 га талбайд гарах зардлыг механик аргаар 53,300 төгрөг, химийн аргаар 40,300 төгрөг байхаар тус тус тооцон гаргажээ.

Энэ төрлийн ургамал нь нэг наст ургамлын төрөлд багтдаг бөгөөд энэхүү ургамлыг үрээ цацахаас өмнө 5, 6 дугаар сард 3 жил дараалан устгавал бүрэн устах боломжтой гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн, эрсдэл бүхий 500 орчим га талбайг сонгон авч 2013 онд орон нутгийн цагдаагийн газрын хөрөнгөөр, 2014, 2015 онд Хууль зүйн яамны /хуучин нэрээр/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлж, устгах арга хэмжээг зохион явуулснаар талбайн хэмжээ 157 га орчим болон багассан бөгөөд зарим газарт устаж үгүй болсон, тархац багасаж, сийрэгжсэн үр дүн гарсан.

Цагдаагийн байгууллагаас хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байна. Тухайлбал:

- "Хар тамхитай холбоотой гэмт хэргийг шалгахад анхаарах зарим асуудал" гарын авлагыг цахим хэлбэрт оруулан хэвлүүлж, орон нутаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтэс, Хилийн тагнуулын газар, Хууль сахиулах их сургууль, Гаалийн ерөнхий газар, Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал дахь Гаалийн газар, Дорноговь аймгийн Замын-Үүд дэх Гаалийн газар, Нийслэлийн прокурорын газарт тарааж, мөн БНХАУ-ын цагдаагийн алба хаагчдын сургалтад ашигладаг "Хар тамхи" сургалтын гарын авлагыг орчуулан албан хэрэгцээнд ашиглаж байна.

-Хууль зүйн яамны /хуучин нэрээр/ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтээр 6 нэр төрлийн 9000 ширхэг зурагт хуудас, 500 ширхэг хуанли, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах тестийг төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн нийтийн тээврийн газар, Хил хамгаалах ерөнхий газарт тус тус хүргүүлсэн.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгжийг татан оролцуулах, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын хүрээнд :

- Хууль зүйн яам, Эрүүл мэнд, спортын яам, Гааль, Татварын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /хуучин нэрээр нь/ болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран 2015 онд "Хар тамхины эсрэг хамтдаа" сэдэвт өдөрлөгийн арга хэмжээг Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал дахь хилийн боомт, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь хилийн боомтод 2016 онд "Мансууралгүй ирээдүй" өдөрлөгийг байгуулсан. Уг арга хэмжээний зорилго нь улсын хилээр нэвтэрч буй гадаад, дотоодын иргэдэд сэрэмжлүүлэг өгөх, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдохгүй байх, сэжигтэй зүйл илэрсэн тохиолдолд хэрхэх тухай анхааруулга, зөвлөмж өгөх явдал байлаа.

-Хууль зүй, дотоод хэргийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, "Цагаан соён" төрийн бус байгууллагатай 2016 онд хамтран "Мансууралгүй ирээдүй" аяныг зохион байгуулж "Мансууралд үгүй гэж хэлье" уриатай явган аялал, "Jets"

автоклубтэй хамтран автомашины жагсаал, “Эир софт” студитэй хамтран 2 төрлийн богино хэмжээний телевизийн сурталчилгаа, сээрэмжлүүлгийг тус тус хийсэн.

Гаалийн ерөнхий газар нь дэлхийн гаалийн байгууллагын гишүүн орны хувьд мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зорилгоор бус нутгийн хамтарсан ажиллагаанд тогтмол оролцох, дотоодын холбогдох хууль сахиулах байгууллагатай хэрэг, зөрчлийн мэдээлэл солилцох, харьяа гаалийн газар, хороодын байцаагч нарыг энэ чиглэлийн гэмт хэрэг, зөрчлийн үйлдлийн арга, хэлбэрийг танилцуулж хамтран ажиллаж байгаа бөгөөд хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлж байгаа.

Шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодис (New Psychotropic Substances буюу NPS)-ын хууль бус эргэлт, хэрэглээ дэлхийн олон улс оронд хурдацтай нэмэгдэж, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой заналхийлж байгаатай холбоотойгоор Дэлхийн гаалийн байгууллагаас хэрэгжүүлж буй SmartCat2 ажиллагаанд Монголын гаалийн байгууллага үндэсний холбоо баригч томилон оролцож байна.

Мөн онгоцоор хил нэвтэрч буй зорчигч, шуудан илгээмж, ачаа тээшийн мэдээллийг онгоц буухаас 2 цагийн өмнө урьдчилан авах, Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал, Замын-Үүд дэх гаалийн газруудад хүний биеийн рентген аппаратаар, харьяа бүх гаалийн байгууллага, салбаруудад ачаа, тээшний рентген аппаратаар болон тусгай бэлтгэгдсэн 40 гаруй албаны эрэлч нохойгоор хяналт тавьж байгаа боловч хар тамхи илрүүлэх зориулалт бүхий /Sabre-5000/ 3 ширхэг аппарат үйлчилгээний зардалгүйгээс ашиглах боломжгүй болсон байна.

Дөрөв. Алба хаагчдыг чадваржуулж, мэргэшүүлэх, одоо ажиллаж буй алба хаагч, ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн талаар

Өнөөдрийн байдлаар Хууль сахиулахын их сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрт Эрүүгийн эрх зүй, Криминалистикийн арга зүй, Зохион байгуулалттай гэмт хэргийн криминалистик шинж, түүнийг мөрдөх арга зүй, Магадлах химиийн арга зүйн чиглэлээр боловсон хүчин бэлтгэж байна.

Цагдаагийн байгууллагын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Бүтэц, зохион байгуулалт батлах тухай Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/23 дугаар тушаалаар Эрүүгийн цагдаагийн албаны харьяа Хар тамхитай тэмцэх газрыг 2 хэлтэс, 33 алба хаагчдын бүрэлдэхүүнтэй өргөжүүлэн байгуулсан.

Алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр ЦЕГ-ын сургалт, дадлагын төвд сургалт зохион байгуулахын зэрэгцээ гадаад улс орнуудаас мэргэжилтэн урьж алба хаагчдыг мэргэшүүлэх, Тайландын Вант Улс, Арабын Бүгд Найрамдах Египет Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шинжян Уйгар, Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Филиппин, Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон зэрэг улс оронд алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах ажлыг тус тус зохион байгуулж байна.

Одоогийн байдлаар цагдаагийн байгууллага нь АНУ-д үйлдвэрлэсэн, хар тамхи, мансууруулах бодис шээнээс илрүүлэгч тест, богино хугацаанд танигч TRUNARC маркийн багажийг ашиглаж байгаа ч, сүүлийн үеийн лабораторийн аргаар боловсруулсан мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг илрүүлэх, таслан зогсооход техник, технологийн хувьд шаардлага хангахгүй байна.

Мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд эд мөрийн баримтаар хураагдсан аливаа бодисод шинжилгээ хийж, хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт, магадлагаа гаргах үүрэг бүхий химийн шинжилгээний лаборатори ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар эрхлэгч-1, ахлах шинжээч-2, шинжээч-2, лаборант-1 орон тоотой үүрэг гүйцэтгэж байна.

Тус лаборатори нь байгалийн болон нийлэг гаралтай мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисод шинжилгээг хийж, холбогдох дүгнэлтийг гаргаж байгаа ч хүний биологийн материал болох үс, цус, шээс, хумсанд уг бодисыг тодорхойлох шинжилгээг хийх техникийн боломжгүй юм. Дээрх төрлийн шинжилгээг хийхэд зориулалтын HPLC-MS загварын тоног төхөөрөмжийг суурилуулах шаардлагатай байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагaa лабораторид эмийн 25 шинжээч, Улаанбаатар хот, 21 аймаг, хилийн 3 боомтод эм, био бэлдмэлийн хяналтын 39 улсын байцаагч тус тус үүрэг гүйцэтгэж байна.

Тав. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

Дээрх төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрх зүйн орчныг сайжруулах, үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлыг үндэслэн 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хурлаас баталсан Эрүү болон Зөрчлийн хуулийн холбогдох зүйлд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Тухайлбал Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлд Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр, Зөрчлийн хуулийн 6.6 дугаар зүйлд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зөрчиж эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, шинэ эм хэрэглээнд гаргах шаардлага, нөхцөлийг зөрчсөн бол зөрчилд тооцон холбогдох торгуулийн арга хэмжээ авахаар тусгагдсан.

Цаашид Монгол Улсын Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, эрүүл амьдралын хэв маягт хэвшүүлэх, хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс гарах үр дагавар, хор уршгийн талаарх ерөнхий мэдлэгийг өсвөр үе, хүүхэд залуучуудад тогтмол олгох, сэтгэл зүйн дархлаа суулгах хөтөлбөр хэрэгжүүлэх замаар урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахаар доорх ажлыг төлөвлөж байна.

-Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор баталсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдүгээр шатныг төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллах,

- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнг мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодисын найрлага, шинж чанарыг тодорхойлох шинжилгээ хийх орчин үеийн багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр хангах, шинжээч, мэргэжилтний чадавхийг сайжруулах,

- Монгол Улсын эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг шинэчлэн боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах,

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд төрийн байгууллагуудыг нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлыг оновчтой болгох, чиг үүрэг бүхий байгууллагын үүргийн давхардалыг арилгаж, уялдаа холбоог сайжруулах,

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг зохион байгуулах, тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр тус тус онцгой анхаарч ажиллаж байна.

---оОо---